

**МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ОЛОН
НИЙТЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТЭДГЭЭРИЙГ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГАСАН БОЛОН ТУСГААГҮЙ САНАЛЫН ТОВЬЁГ**

	Ирүүлсэн санал	Тусгасан байдал, тайлбар
I. Сангийн яамны сайтаар олон нийтийн хэлэлцүүлэгт ирсэн саналууд		
1.	Х.Баярсайхан: 1. Босго оноог багийн хэмжээнд тооцох.	Үгүй. Босго үзүүлэлтийг багаар тооцвол дараах сөрөг үр дагавар гарна. Үүнд: 1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлаж малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа хэрэгждэг. Багийн хорогдолд суурилсан босго үзүүлэлтийг даатгалын компани болон олон улсын давхар даатгалын компани зөвшөөрөхгүй байр суурийг илэрхийлсэн. 2. Даатгалд мэдээллийн найдвар /data credibility/-тай байдал маш чухал юм. Малын хорогдлын хувь нь тухайн сумын нутаг дэвсгэрт төрөл зүйлийн хувьд ихээхэн ялгаатай байдаг. Хязгаарлагдмал мэдээлэл нь хорогдлын түвшинг бууруулж, өөрөөр хэлбэл мэдээллийн хэлбэлзэлд эргэлзээ төрүүлж, нөхөн төлбөр төлөхөд ашиглах боломжгүй байдаг байна. Иймд одоогийн хэрэгжүүлж байгаа МИД-д малын төрөл тус бүрд 5000-аас доош малтай сумыг хонин сүргээр орлуулан тооцож, хураамж болон нөхөн төлбөрийг олгодог. Жишээлбэл, 3 тэмээтэй сум байдаг бөгөөд хэрэв тэмээг хониор орлуулан даатгахгүй бол 3 тэмээгээ хорогдуулаагүй байж хорогдуулсан гэж мэдэгдэн нөхөн төлбөр авах боломж үүснэ. Мөн ихэнх багт байгаа малын төрөл тус бүрийн тоо нь 5000-аас бага байгааг анхаарах хэрэгтэй. 3. Монгол Улсад нийт 330 сум, 1500 орчим баг байдаг. Одоогийн хэрэгжүүлж байгаа МИД-ын бүтээгдэхүүний хураамжийг хувийг тооцоолохдоо 330 сум, малын төрөл тус бүр дээр тооцоолж малчдаас хураамж авдаг. Тэгвэл 1500 баг, малын төрөл тус бүрд хураамжийг тооцоолбол 7500 өөр өөр хураамжийн хувь гарна. Ингэснээр даатгал хийж буй төлөөлөгч будилж төөрөх, малчдаас илүү дутуу

		хураамж авах эрсдэлтэй. Аливаа даатгалын бүтээгдэхүүний энгийн ойлгомжтой байх нь зөв юм. 4. Багийн хорогдлын мэдээг багийн дарга буюу ганц хүн гаргадаг. Нэг хүний мэдээлэлд үндэслэх нь учир дутагдалтай юм. 5. Босго үзүүлэлт нь зарим багт хэт өндөр, зарим багт хэт бага болно. Нөхөн төлбөр өгөх магадлал өсөх бөгөөд их хэмжээний нөхөн төлбөр гарвал МИД-ын тогтолцоо цаашид тогтвортой байхад сөрөг нөлөөтэй.
2.	Х.Баярсайхан: 2. Малын албан татвараас даатгалын шимтгэлийг төлдөг тогтолцоог бий болгох	Үгүй. Батлагдсан хуулийн төслийн үзэл баримтлалд тусаагүй тул хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгах боломжгүй байна.
3.	Х.Баярсайхан: 3. Багийн засаг дарга нарын ажлын байрны тодорхойлолтод сургалт сурталчилгааны талаар оруулах	Үгүй. Хуулийн төсөлд холбогдох зохицуулалт байдаг. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 28.1 дугаар зүйлийн 28.1-т заасны дагуу бүх шатны Засаг дарга хяналт тавих үүрэгтэй. Хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг дээд шатны удирдлага анхаарч, хяналт тавьж ажиллах шаардлагатай.
4.	Х.Баярсайхан: 4.Статистик мэдээ, мэдээллийг сум багийн хэмжээнд үнэн бодитой цаг хугацаанд нь мэдээлдэг тогтолцоог бий болгох үүнийг төрийн байгууллагууд анхаарах.	Үгүй. Салбарын яам хяналт тавих нь зүйтэй бөгөөд хуулийн төсөлд тусгах шаардлагагүй.
5.	Мөнхбаяр: 1.Багийн хэмжээнд хорогдлын хувь буюу босго оноог тооцох	Үгүй. Босго үзүүлэлтийг багаар тооцвол дараах сөрөг үр дагавар гарна. Үүнд: 1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлаж малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа хэрэгждэг. Багийн хорогдолд суурилсан босго үзүүлэлтийг даатгалын компани болон олон улсын давхар даатгалын компани зөвшөөрөхгүй байр суурийг илэрхийлсэн. 2. Даатгалд мэдээллийн найдвар /data credibility/-тай байдал маш чухал юм. Малын хорогдлын хувь нь тухайн сумын нутаг дэвсгэрт төрөл зүйлийн хувьд ихээхэн ялгаатай байдаг. Хязгаарлагдмал мэдээлэл нь хорогдлын түвшинг

		бууруулж, өөрөөр хэлбэл мэдээллийн хэлбэлзэлд эргэлзээ төрүүлж, нөхөн төлбөр төлөхөд ашиглах боломжгүй байдаг байна. Иймд одоогийн хэрэгжүүлж байгаа МИД-д малын төрөл тус бүрд 5000-аас доош малтай сумыг хонин сүргээр орлуулан тооцож, хураамж болон нөхөн төлбөрийг олгодог. Жишээлбэл, 3 тэмээтэй сум байдаг бөгөөд хэрэв тэмээг хониор орлуулан даатгахгүй бол 3 тэмээгээ хорогдуулаагүй байж хорогдуулсан гэж мэдэгдэн нөхөн төлбөр авах боломж үүснэ. Мөн ихэнх багт байгаа малын төрөл тус бүрийн тоо нь 5000-аас бага байгааг анхаарах хэрэгтэй. 3. Монгол Улсад нийт 330 сум, 1500 орчим баг байдаг. Одоогийн хэрэгжүүлж байгаа МИД-ын бүтээгдэхүүний хураамжийг хувийг тооцоолохдоо 330 сум, малын төрөл тус бүр дээр тооцоолж малчдаас хураамж авдаг. Тэгвэл 1500 баг, малын төрөл тус бүрд хураамжийг тооцоолбол 7500 өөр өөр хураамжийн хувь гарна. Ингэснээр даатгал хийж буй төлөөлөгч будилж төөрөх, малчдаас илүү дутуу хураамж авах эрсдэлтэй. Аливаа даатгалын бүтээгдэхүүний энгийн ойлгомжтой байх нь зөв юм. 4. Багийн хорогдлын мэдээг багийн дарга буюу ганц хүн гаргадаг. Нэг хүний мэдээлэлд үндэслэх нь учир дутагдалтай юм. 5. Босго үзүүлэлт нь зарим багт хэт өндөр, зарим багт хэт бага болно. Нөхөн төлбөр өгөх магадлал өсөх бөгөөд их хэмжээний нөхөн төлбөр гарвал МИД-ын тогтолцоо цаашид тогтвортой байхад сөрөг нөлөөтэй.
6.	Мөнхбаяр: 2.Сум, багийн статистикт мэдээ, мэдээллийн мэдээлэх нөхцөлийг сайжруулах. Одоогийн сум, багийн зүгээс статистик мэдээ цаг хугацааг хоцроодог гэх мэт учир дутагдалтай байна.	Үгүй. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-6.4 дэх хэсгүүдэд сумын малын хорогдлыг тогтоох, мэдээлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан байдаг. Тус хуулийн 6.2-т заасны дагуу Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тооллогыг тухайн жилийн 6 дугаар сарын эхний хагаст багтаан түүвэр судалгааны аргаар зохион байгуулах зохицуулалттай. Иймд хуулийн төсөлд тус саналыг тусгах шаардлагагүй.

7.	Мөнхбаяр: 3. Малчдын дунд сургалт сурталчилгааг МИД-н талаар ажлын байрны тодорхойлолтод оруулах.	Үгүй. Хуулийн төсөлд холбогдох зохицуулалт туссан байдаг. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 28.1 дугаар зүйлийн 28.1-т заасны дагуу бүх шатны Засаг дарга хяналт тавих үүрэгтэй. Хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг дээд шатны удирдлага анхаарч, хяналт тавьж ажиллах шаардлагатай.
8.	Эрдэнэцэцэг: Малын хөлийн албан татвараас 5-10 хувь заавал даатгалд оруулж малчин өрх болгон даатгалд хамруулах.	Үгүй. Батлагдсан хуулийн төслийн үзэл баримтлалд тусаагүй тул хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгах боломжгүй байна.
9.	Дулам Өлзийбаатар: Сайн байна уу? Малын хорогдлыг сумын босго гэснээс айл бүрийн малын хорогдлоор тооцож өгвөл илүү шударга санагдлаа жишээн манайх гэхэд 2022 онд адууны хорогдол 100%иас 30% байхад ямар ч нөхөн төлбөр олгогдоогүй яагаад гээд асуухаар танай сумын хорогдол босго оноондоо хүрээгүй гэх хариултыг авсан байгаа	Үгүй. Батлагдсан хуулийн төслийн үзэл баримтлалд тусаагүй тул хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгах боломжгүй байна. Малын индексжүүлсэн даатгал нь нэг талаас маш өндөр зардал болон эрсдэлтэй учир даатгалын компаниуд даатгал хийх сонирхолгүй, бас хангалттай нөөц хөрөнгө бүрдүүлэхэд хүндрэлтэй тул зудын гамшгийн эрсдэлийн даатгалын тогтолцоог эвдэх магадлалтай байна.
10.	Цогтбаяр: Сумын хэмжээний хорогдлыг багийн түвшинд оруулах. Малын даатгал албан журам болгох. Малын хөлийн албан татвараас 10 хувь заавал даатгалд оруулж малчин өрх болгон даатгалд хамруулах.	Үгүй. Босго үзүүлэлтийг багаар тооцвол дараах сөрөг үр дагавар гарна. Үүнд: 1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлаж малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа хэрэгждэг. Багийн хорогдолд суурилсан босго үзүүлэлтийг даатгалын компани болон олон улсын давхар даатгалын компани зөвшөөрөхгүй байр суурийг илэрхийлсэн. 2. Даатгалд мэдээллийн найдвар /data credibility/-тай байдал маш чухал юм. Малын хорогдлын хувь нь тухайн сумын нутаг дэвсгэрт төрөл зүйлийн хувьд ихээхэн ялгаатай байдаг. Хязгаарлагдмал мэдээлэл нь хорогдлын түвшинг бууруулж, өөрөөр хэлбэл мэдээллийн хэлбэлзэлд эргэлзээ төрүүлж, нөхөн төлбөр төлөхөд ашиглах боломжгүй байдаг байна. Иймд одоогийн хэрэгжүүлж байгаа МИД-д малын төрөл тус бүрд 5000-аас доош малтай сумыг хонин сүргээр

		орлуулан тооцож, хураамж болон нөхөн төлбөрийг олгодог. Жишээлбэл, 3 тэмээтэй сум байдаг бөгөөд хэрэв тэмээг хониор орлуулан даатгахгүй бол 3 тэмээгээ хорогдуулаагүй байж хорогдуулсан гэж мэдэгдэн нөхөн төлбөр авах боломж үүснэ. Мөн ихэнх багт байгаа малын төрөл тус бүрийн тоо нь 5000-аас бага байгааг анхаарах хэрэгтэй. 3. Монгол Улсад нийт 330 сум, 1500 орчим баг байдаг. Одоогийн хэрэгжүүлж байгаа МИД-ын бүтээгдэхүүний хураамжийг хувийг тооцоолохдоо 330 сум, малын төрөл тус бүр дээр тооцоолж малчдаас хураамж авдаг. Тэгвэл 1500 баг, малын төрөл тус бүрд хураамжийг тооцоолбол 7500 өөр өөр хураамжийн хувь гарна. Ингэснээр даатгал хийж буй төлөөлөгч будилж төөрөх, малчдаас илүү дутуу хураамж авах эрсдэлтэй. Аливаа даатгалын бүтээгдэхүүний энгийн ойлгомжтой байх нь зөв юм. 4. Багийн хорогдлын мэдээг багийн дарга буюу ганц хүн гаргадаг. Нэг хүний мэдээлэлд үндэслэх нь учир дутагдалтай юм. 5. Босго үзүүлэлт нь зарим багт хэт өндөр, зарим багт хэт бага болно. Нөхөн төлбөр өгөх магадлал өсөх бөгөөд их хэмжээний нөхөн төлбөр гарвал МИД-ын тогтолцоо цаашид тогтвортой байхад сөрөг нөлөөтэй.
II. Олон нийтийн хэлэлцүүлгээр ирсэн саналууд:		
1.	Архангай аймгийн малчин Нацагдорж: Мэргэжлийн байгууллагуудаас цаг агаарын байдаг улам хүндэрнэ гэж байгаа. Бид бүгдийн хувьд ганц найдах зүйл нь даатгал байна. Иймд нийт малчдын даатгалд хамрагдахыг уриалж байна. Даатгалын санд хэмжээний хөрөнгө хуримтлуулж, даатгалын донор байгууллагуудтай хамтран ажиллах нь зүйтэй. Бэлчээр, цаг агаарын байдаг гайгүй жилүүдэд заавал нөхөн төлбөр авах шаардлагагүй. Харин энэ мөнгөө хуримтлал болгон арвижуулах шаардлагатай. Малчид маш бага мөнгөөр даатгуулж байна. Ерөнхийдөө сумын аварга малчин болох гэж даатгуулж байна. Энийг болимоор байна.	Үгүй. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 10.1-т “Энэ хуулийн 6.3-т заасны дагуу нийтэд мэдээлсэн сумын малын хорогдол Засгийн газраас тогтоосон нэгдүгээр босго үзүүлэлтээс давсан бол даатгалын тохиолдол бий болсон гэж үзнэ.” гэж заасан байдаг тул зөвхөн босго үзүүлэлт давсан тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг олгодог. Мөн Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-т заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо, бүх шатны Засаг дарга, давхар даатгалын компанийн удирдлага нь хуулийн биелэлтэд хяналт тавьдаг байна.

2.	Сүхбаатар аймгийн малчин Бямбадорж: Малын индексжүүлэн даатгалыг албан журмын болгох тохиолдолд малчдад дарамт ирнэ. МИД-ыг банкууд хийж өгч байгаа, мөн зээлийн хүүг бууруулж өгч байгааг анхаарах шаардлагатай. Малчид олноороо хамрагдахад хөшүүргийг сайн хийж өгөх шаардлагатай байна.	Тийм. Малчдыг даатгалд хамруулах хөшүүргийг дагалдах хуульд тусгасан.
3.	Төв аймгийн малчин, даатгалын төлөөлөгч Түвшинбаяр: Малын үнэлгээг анхаарах нь зүйтэй. Малчид банканд даатгал хийлгэхдээ малын индексжүүлсэн даатгал уу, эсвэл зээлийн эрсдэлийн даатгал уу гэдгээ ялгахгүй байна.	Хуулийн төсөлд тусгах шаардлагагүй санал.
4.	Дорноговь аймгийн Бодь даатгалын компанийн төлөөлөл Цэрэнчимэд: Даатгалын хувь хэмжээг багасгах нь зөв. Даатгалын асуудлыг сумдын ажлын үзүүлэлтэд оруулах шаардлагатай. Сумын хорогдол хөөсрөлтэй байдаг тул анхаарах шаардлагатай. Бүх шатны ажилд тусгах шаардлагатай.	Үгүй. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 28.1-т заасны дагуу бүх шатны Засаг дарга хяналт тавих үүрэгтэй бөгөөд хэрэгжилт хангалтгүй байгаа тул дээд шатны удирдлага хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.
5.	Архангай аймгийн малчин Зоригтбаатар: Нэг сум, нэг аймгийн хувийг харгалзаж үзмээр байна.	Үгүй. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн үндсэн үзэл баримтлалд нийцэхгүй хуулийн үзэл баримтлалд тусаагүй тул хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгах боломжгүй байна. Малын индексжүүлсэн даатгал нь нэг талаас маш өндөр зардал болон эрсдэлтэй учир даатгалын компаниуд даатгал хийх сонирхолгүй, бас хангалттай нөөц хөрөнгө бүрдүүлэхэд хүндрэлтэй тул зудын гамшгийн эрсдэлийн даатгалын тогтолцоог эвдэх магадлалтай байна.
6.	Архангай аймгийн малчин Зоригтбаатар: Банк малыг 1,2 төрлөөр л үнэлж даатгаж байгааг анхаарах шаардлагатай байна.	Тийм. Босго үзүүлэлт болон хураамжийг аймаг, сум бүрээр ялгаатай тогтоодог.
7.	Увс аймгийн малчин Лхагвадорж: Даатгалыг малчдад сурталчлах шаардлагатай байна. Ашиг тусыг малчид төдийлөн сайн мэдэхгүй байна. Малчны хэлэлцүүлгийг цаашид үргэлжлүүлэх шаардлагатай, цаг уурын мэдээллийг	Хуулиар зохицуулах шаардлагагүй.

	малчдад хүргүүлэх шаардлагатай байна.	
8.	Увс аймгийн малчин Лхагвадорж: Малчдад нөхөн төлбөрийн урьдчилж өгмөөр байна. Нөгөөхөөр нь малаа эрсдэл багатай аваад гарчих болов уу.	Тийм. Хуулийн төсөлд тусгасан.
11.	Баянхонгор аймгийн малчин: Босго үзүүлэлтийг багасгаад өгчихвөл малчид ихээр хамрагдахаар байна.	Тийм. Босго үзүүлэлтийг уян хатан тогтоох зохицуулалтыг тусгасан.
12.	Бодь даатгалын компанийн төлөөлөгч Мягмарсүрэн: Малчид олон жил дараалан даатгал хийлгэдэг, ихэнх жилүүдэд нөхөн төлбөр авч чаддаггүй. Банкны ажилчид даатгалын төлөөлөл биш. Банк өөрийн зээлийн малчдад олгохын тулд зөвхөн банк дээр даатгал хийлгэх тохиолдолд зээл олгоно гэдэг. Даатгалын төлөөлөл дээр хийгдсэн даатгалын гэрээг хүлээн зөвшөөрдөггүй. Энэ зөрчлийг арилгах шаардлагатай байна. Малчид МИД-ын даатгал зээлийн эрсдэлийн даатгалаа ялгадаггүй тул буруу ойлголттой байгаад байна. Банк нэгэнт зуучлалын ажил хийж байгаа бол МИД-ыг сурталчлаад малчдад мэдээлэл өгөх шаардлагатай байна.	Үгүй. Хуулийн төсөлд оруулах шаардлагагүй. Тус саналыг гэрээгээр зохицуулах боломжтой.
13.	Говьсүмбэр аймгийн малчин Олонбаатар: МИД-ын даатгал хаврын эрсдэлийг даатгаж байгаа. Малын хорогдолыг 7-8 сарын хорогдолыг хуулинд тусгах хэрэгтэй. Даатгалын хугацаа 6 дугаар сарын 30-нд дуусчихдаг. Хугацааг нь сунгаад 8 дугаар сарын 15 хүртэл хугацааг сунгах хүсэлтэй байна.	Хуулийн төсөлд тусгах шаардлагагүй санал.
14.	Даатгалын хорогдлын мэдээг сум, багийн ЗГ-аар дамжуулж гаргаж байгаа. Нөхөн төлбөрийн мөн сум, багын ЗГ-аар дамжуулж олгох замаар хэрэгжүүлэх боломжтой юу?	Үгүй. Даатгалын гэрээгээр зохицуулах тул хуульд оруулах шаардлагагүй.
15.	Сумын хорогдлын хэмжээ нэлээд өндөр гарсан тохиолдолд нөхөн төлбөрийн урьдчилж олгодог байвал. Малчдын бэлдсэн өвс тэжээл дуусан тохиолдолд дахиад тэжээл авах зорилгоор банкнаас зээл авдаг. Нөхөн төлбөрөө урьдчилж	Тийм. Хуулийн төсөлд тусгасан.

	олгодог байвал зээл авах шаардлага үүсэхгүй.	
12.	Нөхөн төлбөрийг 9-10 сар хүртэл удаах асуудлыг наашлуулж, 7-8 сард олгох хэрэгтэй байна	Тийм. Нөхөн төлбөрийг 7-8 сард олгох боломжтой.
	Малчин Туяа: 6 хувь гэж тогтоосон босго үзүүлэлтийг бууруулах саналтай байна.	Тийм. Босго үзүүлэлтийг уян хатан тогтоох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.
12.	Увс аймгийн малчин: Орон нутаг аймгийн босго үзүүлэлтийг тухайн үеийн нөхцөл байдалтай холбож тооцох нь зөв санаа гэж үзэж байна.	Тийм. Босго үзүүлэлтийг аймаг, сумын өмнө жилүүдийн малын хорогдлын тоонд үндэслэн уян хатан тогтоох зохицуулалтыг тусгасан.
13.	Тухайн малчны бодит хохирлоос бус сумын дундаж хохирлоос тооцож нөхөн төлбөр олгодог. Олон жил даатгалд хамрагдаж буй малчдад нөхөн олговор олгох, урамшуулал авмаар байна.	Үгүй: Даатгалын гэрээгээр зохицуулах боломжтой тул хуульд тусгах шаардлагагүй.
14.	Завхан аймгийн малчин: Төр захиргааны байгууллагад хандалт байхгүй байна. Шат шатны засаг дарга нарт хуулийн хэрэгжилтийг хангуулах, сурталчлан таниулах асуудлын мөрийн хөтөлбөрт, ажилд нь тусгах шаардлагатай байна.	Тус хуулийн 28.1-т заасны дагуу бүх шатны Засаг дарга хяналт тавих үүрэгтэй бөгөөд хэрэгжилт хангалтгүй байгаа тул дээд шатны удирдлага хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.
15.	Завхан аймгийн малчин: Малын индексжүүлсэн даатгалын босго үзүүлэлтийн жоохон бууруулах саналтай байна.	Тийм. Босго үзүүлэлтийг аймаг, сумын өмнө жилүүдийн малын хорогдлын тоонд үндэслэн уян хатан тогтоох зохицуулалтыг тусгасан.
16.	Завхан аймгийн малчин: МИД-ын даатгалын албан журмын болгох саналтай байна.	Үгүй. Мал бол хувийн өмч. 1990-ээд оны мал хувьчлалаар малаа малчид өмчлөх болж, байгалийн эрсдэлтэй олон аргаар тэмцэж ирсэн. Жишээлбэл, өвс тэжээл бэлтгэх, хашаа хороо барих, худаг ус гаргах, малаа вакцинд хамруулах, эрүүлжүүлэх, үүлдэр угсааг нь сайжруулах, туслах малчин ажиллуулах, отор нүүдэл хийх гэх мэт аргууд байна. Иймд малын даатгал бол малчин хүний хувьд хийж болох эрсдэлээ удирдах сонголтуудын нэг хэсэг бөгөөд малчдын өмч, орлогын эх үүсвэрийг хамгаалах зорилготой болохоос

		хариуцлагын даатгал биш бөгөөд сайн дурын үндсэн дээр хийгддэг байх шаардлагатай. Малын индексжүүлсэн даатгалыг албан журмын болгох нь малчдын сонголтоо хийх ашиг сонирхлын эсрэг бөгөөд нэг жилд тохиолдох эрсдэлийн хариуцлагын хэмжээ нь манай улсын өнөөгийн төсвөөс давах аюултай. 2023 оны жилийн эцсийн мал тооллогоор 64.7 сая мал тоологдсон бөгөөд нийт 17.8 их наяд төгрөгийн хариуцлага байна. Энэ хариуцлагыг 2010, 2024 онд болсон зудын эрсдэлийн хохирол шиг эрсдэл гарвал даатгалын компани, давхар даатгал хариуцаж чадахгүй бөгөөд улсын төсвөөс санхүүжүүлэх зайлшгүй шаардлага гарч улсын төсвийн тогтвортой байдал алдагдахад хүрнэ.
17.	Хөвсгөл аймгийн малчин Хүнбиш: МИД-д малчид хамрагдахгүй олон шалтгаан байгаа. Хамрагдалт муу учраас зудын эрсдэл тохиосон ч гэсэн босго үзүүлэлт давах магадлал бага гэж үзэж байна. Даатгалд олон малчид хамрагдах юм бол түүвэр судалгаа үзэн зөв гарна гэж үзэж байна.	Тийм. Босго үзүүлэлтийг уян хатан болгосон.
18.	Болормаа: Банкны ажилчид даатгалын ажилчид биш, малчдыг хөхүүлэн дэмжих нь зүйтэй. Босго үзүүлэлт, даатгалын хураамж өндөр тул малчид төдийлөн хамрагддаггүй. Иймд босго үзүүлэлт, хураамжийн хувийг бууруулах шаардлагатай.	Тийм. Босго үзүүлэлтийг уян хатан болгосон
19.	Болормаа: Засга дарга нарын мөрийн хөтөлбөрт, төрийн албан хаагчдын ажилд даатгалын ажлыг оруулж өгөх, даатгалын компаниудтай хамтран ажиллаж сурталчлан таниулах шаардлагатай байна.	Үгүй. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 28.1-т заасны дагуу бүх шатны Засаг дарга хяналт тавих үүрэгтэй бөгөөд хэрэгжилт хангалтгүй байгаа тул дээд шатны удирдлага хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.
20.	Хөвсгөл аймгийн малчин Нямлхагва: Гэнэтийн осол, гамшигтай холбоотой асуудлыг тусгах.	Тийм. Том малын зүй бус хорогдолд гэнэтийн осол, гамшигтай холбоотой асуудлуудыг тусгадаг.

21.	Албан журмын даатгал болгох замаар гамшгийн эрсдэлээс сэргийлэх;	Үгүй. Мал бол хувийн өмч. 1990-ээд оны мал хувьчлалаар малаа малчид өмчлөх болж, байгалийн эрсдэлтэй олон аргаар тэмцэж ирсэн. Жишээлбэл, өвс тэжээл бэлтгэх, хашаа хороо барих, худаг ус гаргах, малаа вакцинд хамруулах, эрүүлжүүлэх, үүлдэр угсааг нь сайжруулах, туслах малчин ажиллуулах, отор нүүдэл хийх гэх мэт аргууд байна. Иймд малын даатгал бол малчин хүний хувьд хийж болох эрсдэлээ удирдах сонголтуудын нэг хэсэг бөгөөд малчдын өмч, орлогын эх үүсвэрийг хамгаалах зорилготой болохоос хариуцлагын даатгал биш бөгөөд сайн дурын үндсэн дээр хийгддэг байх шаардлагатай. Малын индексжүүлсэн даатгалыг албан журмын болгох нь малчдын сонголтоо хийх ашиг сонирхлын эсрэг бөгөөд нэг жилд тохиолдох эрсдэлийн хариуцлагын хэмжээ нь манай улсын өнөөгийн төсвөөс давах аюултай. 2023 оны жилийн эцсийн мал тооллогоор 64.7 сая мал тоологдсон бөгөөд нийт 17.8 их наяд төгрөгийн хариуцлага байна. Энэ хариуцлагыг 2010, 2024 онд болсон зудын эрсдэлийн хохирол шиг эрсдэл гарвал даатгалын компани, давхар даатгал хариуцаж чадахгүй бөгөөд улсын төсвөөс санхүүжүүлэх зайлшгүй шаардлага гарч улсын төсвийн тогтвортой байдал алдагдахад хүрнэ.
22.	Өмнөговь аймгийн малчин Цогбаяр: Өмнөговь аймаг нь Улсын төсвийн 80 гаруй хувийг бүрдүүлдэг онцлогтой аймаг. Манай аймагт зудын аюул гэхээс илүү авто зам, төмөр зам дээр их хэмжээний малаа алдаж байна. Энэ асуудлыг мөн даатгалд оруулмаар байна.	Үгүй. Бусад эрсдэл нь хагас жилийн мал тооллогоос хойш гардаг тул хуулийн үндсэн тогтолцоонд өөрчлөлт орж шинэчилсэн найруулга хийх шаардлагатай. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд тус саналыг тусгах боломжгүй.
23.	Булган аймгийн малчин Эрдэнэбат: Бороо ус, аянга цахилгааны асуудалд нөхөн төлбөр олгомоор байна.	Хуулийн үндсэн тогтолцоо нь хагас жилийн мал тооллогод үндэслэн нөхөн төлбөр олгодог. Бусад эрсдэл нь хагас жилийн мал тооллогоос хойш гардаг тул хуулийн үндсэн тогтолцоонд өөрчлөлт орж шинэчилсэн найруулга хийх шаардлагатай тул нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд оруулах боломжгүй.

24.	Булган аймгийн малчин Эрдэнэбат: Гоц халдварт өвчинд хорогдсон малд нөхөн төлбөр олгомоор байна	Үгүй. Гоц халдварт өвчний улмаас учирсан хохирлыг улсын төсвөөс нөхөн төлдөг тул даатгалд хамруулах шаардлагагүй.
25.	Завхан аймгийн ХХААГ-ын дарга Мөнххүрэл: 1) Албан журмаар даатгуулах асуудлын тусгах нь зүйтэй 2) Ноос ноолуур, арьс ширний урамшуулал олгоход МИД хамрагдсан эсэхийг хөшүүрэг болгож оруулах нь зүйтэй байна. 3) Малчид бүгд хамрагдаад ирэх юм бол 6 хувийн босго үзүүлэлт боломжтой, эрсдэл үүсэх эсэхийг давхар бодолцох нь зүйтэй байна.	Давхардсан саналууд.
21.	Дорноговь аймгийн Бодь даатгалын төлөөлөгч Наранболд: 1.Шагнал авч буй малчид болон зээл авч буй малчид л хүчээр даатгуулж байгаа тул даатгалын хамрагдалт муу байна. ХХААХҮЯ-ны сайд нь тушаал гаргах шаардлагатай юу? эсвэл МИД-ын хууль дээр оруулах хэрэгтэй юу? Ямартай ч сумын Засаг дарга нарт даатгалын асуудлыг үүрэг болгож өгөх шаардлагатай байна. 2.Өвөл сумаас өвс, тэжээл олгох бол даатгалд хамрагдсан өрхөд давуу эрхтэй өгөх нь зүйтэй байна. 3.Хагас жилийн тооноос хойш даатгалын хугацаа дуусаж байгаа. Даатгалын хугацааг бүтэн жилээр даатгаж болох уу?	1.Тус хуулийн 28.1-т заасны дагуу бүх шатны Засаг дарга хяналт тавих үүрэгтэй бөгөөд хэрэгжилт хангалтгүй байгаа тул дээд шатны удирдлага хяналт тавьж ажиллах шаардлагатай байна. 2.Тус саналыг хуульд тусгах шаардлагагүй бөгөөд хууль батлагдсантай холбоотой гарах УИХ-ын тогтоол, ХХААХҮЯ-ны сайдын тушаал, эсвэл аймаг, сумын Засаг дарга нар зохицуулах боломжтой. 3.Цаг уурын нөхцөл байдлыг малчид урьдчилан мэдэх боломжтой тул даатгалын тогтолцоонд сөрөгөөр нөлөөлөх, даатгалын залилан үүсэж, тус даатгалын үндсэн тогтолцоонд сөрөг нөлөө үзүүлэх боломжтой.
22.	Төв аймгийн малчин Баасансүрэн: Албан журмын даатгал болгох шаардлагатай байна.	Үгүй. Мал бол хувийн өмч. 1990-ээд оны мал хувьчлалаар малаа малчид өмчлөх болж, байгалийн эрсдэлтэй олон аргаар тэмцэж ирсэн. Жишээлбэл, өвс тэжээл бэлтгэх, хашаа хороо барих, худаг ус гаргах, малаа вакцинд хамруулах, эрүүлжүүлэх, үүлдэр угсааг нь сайжруулах, туслах малчин ажиллуулах, отор нүүдэл хийх гэх мэт аргууд байна. Иймд малын даатгал бол малчин хүний хувьд хийж болох эрсдэлээ удирдах сонголтуудын нэг хэсэг бөгөөд малчдын өмч, орлогын эх үүсвэрийг хамгаалах зорилготой болохоос

		хариуцлагын даатгал биш бөгөөд сайн дурын үндсэн дээр хийгддэг байх шаардлагатай. Малын индексжүүлсэн даатгалыг албан журмын болгох нь малчдын сонголтоо хийх ашиг сонирхлын эсрэг бөгөөд нэг жилд тохиолдох эрсдэлийн хариуцлагын хэмжээ нь манай улсын өнөөгийн төсвөөс давах аюултай. 2023 оны жилийн эцсийн мал тооллогоор 64.7 сая мал тоологдсон бөгөөд нийт 17.8 их наяд төгрөгийн хариуцлага байна. Энэ хариуцлагыг 2010, 2024 онд болсон зудын эрсдэлийн хохирол шиг эрсдэл гарвал даатгалын компани, давхар даатгал хариуцаж чадахгүй бөгөөд улсын төсвөөс санхүүжүүлэх зайлшгүй шаардлага гарч улсын төсвийн тогтвортой байдал алдагдахад хүрнэ.
23.	Үндэсний давхар даатгал ХК-ын ТУЗ-ын хараат бус гишүүн Дашдондог: Малын индексжүүлсэн даатгалын хуулийн төсөлтэй 24.3-т өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна. Давхар даатгалын компани нь санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлтийг дараа жилийн 3 сарын 1-ны дотор ТУЗ-өөр баталгаажуулна гэж заасан байдаг. 3 сарын 1-нд тайланг батлуулах боломжгүй байдаг тул энэ цагалбарыг өөрчлөх хүсэлтэй байна. Жишээлбэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд аж ахуйн нэгж, байгууллага нь 2 сарын 10-ны дотор тайлан мэдээллээ гаргаж санхүүгийн байгууллагад хүргүүлэх гэж заасан байдаг, мөн Төсвийн тухай хуульд төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд 2 сарын 15-ны төрийн аудитын байгууллагад хүргүүлэх, аудитын байгууллагад хүргүүлсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах байгууллагад хүргүүлнэ гэж заасан байдаг. Гэтэл Малын индексжүүлсэн даатгалын хуульд 3 дугаар сарын 1 гэсэн байдаг тул энэ хугацаанд тайлан тооцоог хэрэгжүүлэх боломжгүй байдаг тул 3-р сарын 1 гэсэн цагалбарын 4-р сарын 1 болгох хойшлуулах саналтай байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 4-р сарын 30-ны дотор хуралдуулах зохицуулалттай иймд тус хурлаас өмнө ТУЗ-аар батлуулах боломжтой.	Тийм. Саналыг тусгасан.

24.	Дорнод аймгийн малчин Энхтуяа: 1) төрийн байгууллагын албан хаагчид хуулийн талаарх ойлголт байдаггүй тул ажил үүрэгт нь тусгаж, хуулийн сурталчилгааг хийх хэрэгтэй байна. 2) малын хорогдлын босго үзүүлэлтийг бүс нутагт ялгаатай тусгаад өгвөл сайн байна	1) Тус хуулийн 28.1-т заасны дагуу бүх шатны Засаг дарга хяналт тавих үүрэгтэй бөгөөд хэрэгжилт хангалтгүй байгаа тул дээд шатны удирдлага хяналт тавьж ажиллах шаардлагатай байна. 2) Үгүй. Даатгалын босго үзүүлэлтийг аймаг, сум тус бүр ялгаатай тогтоох боломжтой.
25.	Говь-Алтай аймгийн малчин Нямжав: даатгалыг албан журмын болгох нь зөв байна.	Үгүй. Мал бол хувийн өмч. 1990-ээд оны мал хувьчлалаар малаа малчид өмчлөх болж, байгалийн эрсдэлтэй олон аргаар тэмцэж ирсэн. Жишээлбэл, өвс тэжээл бэлтгэх, хашаа хороо барих, худаг ус гаргах, малаа вакцинд хамруулах, эрүүлжүүлэх, үүлдэр угсааг нь сайжруулах, туслах малчин ажиллуулах, отор нүүдэл хийх гэх мэт аргууд байна. Иймд малын даатгал бол малчин хүний хувьд хийж болох эрсдэлээ удирдах сонголтуудын нэг хэсэг бөгөөд малчдын өмч, орлогын эх үүсвэрийг хамгаалах зорилготой болохоос хариуцлагын даатгал биш бөгөөд сайн дурын үндсэн дээр хийгддэг байх шаардлагатай. Малын индексжүүлсэн даатгалыг албан журмын болгох нь малчдын сонголтоо хийх ашиг сонирхлын эсрэг бөгөөд нэг жилд тохиолдох эрсдэлийн хариуцлагын хэмжээ нь манай улсын өнөөгийн төсвөөс давах аюултай. 2023 оны жилийн эцсийн мал тооллогоор 64.7 сая мал тоологдсон бөгөөд нийт 17.8 их наяд төгрөгийн хариуцлага байна. Энэ хариуцлагыг 2010, 2024 онд болсон зудын эрсдэлийн хохирол шиг эрсдэл гарвал даатгалын компани, давхар даатгал хариуцаж чадахгүй бөгөөд улсын төсвөөс санхүүжүүлэх зайлшгүй шаардлага гарч улсын төсвийн тогтвортой байдал алдагдахад хүрнэ.
26.	Баянхонгор аймгийн даатгалын төлөөлөгч: 1) Аймгийн босго үзүүлэлтийг 3 хувь болгох саналтай байна.	1) Босго үзүүлэлтийг актуар тооцоололд үндэслэн уян хатан тогтооно. 2) Аймаг, сум бүрд ялгавартай тогтоох боломжтой.

	2) Сум болгонд босго үзүүлэлт гэж гаргах саналтай байна. 3) Байгалын гамшиг, галын аюул зэргийг даатгалд оруулах саналтай байна. 4) Аймгуудын засаг дарга, багыг дарга нарын ажилд даатгалыг оруулж өгөх саналтай байна.	3)Байгалын гамшиг, галын аюул зэргийг даатгалд оруулах боломжгүй. 4) Тус хуулийн 28.1-т заасны дагуу бүх шатны Засаг дарга хяналт тавих үүрэгтэй бөгөөд хэрэгжилт хангалтгүй байгаа тул дээд шатны удирдлага хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.
27.	Дорноговь аймаг дахь МИГ даатгалын төлөөлөгч Уранцэцэг: Хууль оруулж буй 2 өөрчлөлтийг баяртай хүлээж авч байна. 1) Олон жил даатгалд хамрагдсан ч нөхөн төлбөр авч чаддаггүй малчдад урамшуулал олгох хэрэгтэй байна. 2) Малын эрсдэлийн даатгалд малын хулгайтай холбоотой асуудлыг оруулах боломжтой эсэх.	1) Даатгалын гэрээний дагуу шийдвэрлэх боломжтой. 2) Малын хулгайтай холбоотой хорогдлыг оруулж тооцдог.
28.	Практикал даатгал ХХК: Банкны оролцоог нэмэгдүүлмээр байна. МИД нь малчны малын даатгал биш банкны малчны зээлийн даатгал болчихоод байна. Банк борлуулалтаас 25%-ийн шитгэл авдаг хэр нь эрсдэл хүлээхгүй байна. Үүн дээр Сангийн яам, Монгол банк ямар оролцоотой байна вэ? Өндөр хэмжээний хохирол гарсан тохиолдолд шимтгэлийг буцаан олгодог нөхцөлийг бүрдүүлэх саналтай байна. Эсвэл дундын эрсдлийн санг бий болгох үед банк шимтгэлээ буцааж өгөөчээ гэсэн саналтай байна.	Үгүй. МИД-ын хуулиар зохицуулах боломжгүй. Даатгалын мэргэжлийн оролцогчдын тухай хуульд заасны дагуу зуучлалын гэрээгээр зохицуулдаг харилцаа.
29.	Практикал даатгал ХХК: Хонины үнэ ямааны үнийг салгаж өгөх малчид ямаанаас илүү хохирол аваад байна. Ямааны үнийг сегментлэх, орлогын эх үүсвэрийг бүрдүүлж байгаа малыг хохиролд бага өртүүлэх үнийг өсгөх боломж байдаг уу, малыг төрлийг сегментлэж үнийг өндөр нам байлгах тал дээр яаж шийдвэрлэх вэ?	Тийм. Малын үнэлгээг үндэсний статистикийн хорооноос гаргасан зах зээлийн үнэлгээг үндэслэн таван төрөл малаар ялгаатай тогтоодог.
30.	Тэнгэр даатгал: МИД-ын тухай хууль болон холбогдох журамд босго үзүүлэлтийг тухайн цаг үеийн судалгаанд үндэслэн шинэчилдэг болох саналтай байна.	Тийм. Босго үзүүлэлтийг гурван жил тутам, хураамжийн жил бүр шинэчлэн тогтоох боломжтой.
31.	Онцгой байдлын ерөнхий газар: МИД-ын тухай хууль болон холбогдох журамд нэгдүгээрт индекс-ийн босгыг бууруулах саналтай байна. Малын хорогдлыг сумаар биш малчны	Үгүй. Босго үзүүлэлтийг уян хатан тогтоох зохицуулалтыг тусгасан. Уламжлалт даатгалын тогтолцоог тус хуулиар зохицуулах боломжгүй.

	хотонд гарсан хохирлоор тооцож нөхөн төлбөр олгодог уламжлалт даатгалын сэргээх	
32.	Улаанбатар Хотын Даатгал ХХК: МИД-ын тухай хууль болон холбогдох журамд босго үзүүлэлт тодорхой давтамжтайгаар өөрчлөгдөн шинэчлэгдэж байх зайлшгүй шаардлагатай.	Тийм. Босго үзүүлэлтийн 3 жил тутам актуар тооцололд үндэслэн уян хатан тогтооно.
33.	Мөнх даатгал: Хохирлыг бууруулах чиглэлийн дагуу авсан арга хэмжээний зардлыг даатгалын нөхөн төлбөр дээр нэмж тооцож олгоно гэсэн хуулийн заалт байдаг. Харин МИД-ын хуульд хагас жилийн мал тооллогын дүнг үндэслэн нөхөн төлбөр олгоно гэсэн хатуу заалттай. Энэ 2-ын хоорондын уялдааг холбох зорилгоор нөхөн төлбөр бууралттай холбоотой гарсан зардлыг нөхөн төлбөр дээр нэмж тооцож олгоно гэж хуулийн төсөл дээр нэмж оруулах саналтай байна.	Тийм. Нөхөн төлбөрийг урьдчилж олгох зохицуулалт тусгасан.
34.	Мөнх даатгал: Хуулийн асуудлаа л ярьцгаая. Босго үзүүлэлтийг компани, мэргэжлийн байгууллагууд өөрсдөө тогтоогоод явах нь зөв.	Тийм. Босго үзүүлэлтийг мэргэжлийн актуарчдын тооцоололд үндэслэн тогтооно.
35.	Мөнх даатгал: Хуучин хууль дээр 17.3 гэсэн заалтыг сэргээх саналтай байна.	Үгүй. Төрийн оролцоог бууруудах, давхар даатгалын компанийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх зорилгоор тус зохицуулалтыг хасч байсан тул дахин сэргээх шаардлагагүй.
36.	Ард даатгал: МИД-ын тухай хууль болон холбогдох журамд Цаг уурын мэдээ, урьдчилсан судалгааг малчид, даатгуулагч, даатгагч ОБЕГ холбогдох газруудад хүргэх, урьдчилсан сургийлэх нь маш чухал байна. Хамрагдалтаа сайжруулхын тулд албажуулах хэрэгтэй гэсэн саналтай байна.	Хэсэгчлэн тусгав. Хамтын эрсдэлийн сангийн журамд өөрчлөлт оруулна, мөн дагалдах хуульд даатгалд хамрагдах хөшүүрэг оруулсан
37.	Төрийн банк: Үнэлгээний хувьд зээлийн хэмжээнээс хамаардаггүй. Банкны хөшүүргийн хувьд сайн малчны зээл. Үнэлгээг программ дээрээ боловсронгуй болгох хэрэгтэй. Процессыг хоорондоо тохироод гэрээ байгуулаад явах хэрэгтэй.	Тийм. малын тооноос хамаарч үнэлгээ болон хураамжийг ялгавартай тогтоож байгаа.